



## ХИЧЭЭЛ 8

УНШИХ ЗҮЙЛ: ҮЙЛС 16:16-34; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 211-220.

## Шоронд

Паул, Силас хоёр шоронд хоригджээ.  
Тэд ямар зүйл ярин гомдоллож болох  
байсан ч тэд Есүсийг хайрлаж,  
бусдаас өөр зүйл хийсэн юм.  
Есүсийг тэд хэрхэн гэрчилснийг  
харцгаая.



нэ хүмүүс бол  
Ертөнцийн  
агуу Их  
Эзэний зарц  
нар. Та нарт хэрхэн  
аврагдахыг тэд одоо

зааж өгч байна."

Паул, Силас хоёр эргэн харав. Муу ёрын сүнстэй нэгэн охин тэднийг дагаж  
байлаа. Охин хүмүүст тэдэнд юу тохиолдох гэж байгааг  
урьдчилан хэлдэг байсан тул эзэд нь түүний энэ байдлыг  
ашиглан мөнгө олдог байлаа. Охин олон өдрийн турш Паул,  
Силас хоёрыг дагаж нөгөө л зүйлээ хашгирсаар явсан юм.

Хэдийгээр охин гарцаагүй үнэн зүйлийг хэлж байсан ч  
гэсэн Христэд итгэгчдэд муу ёрын сүнс ч бас хамаатай гэдэг  
ойлголтыг тэд хүмүүст өгөхийг хүссэнгүй. Эцэст нь Паул  
охинд хандаж, муу ёрын сүнсэнд нь ингэж тушаалаа. "Есүс  
Христийн нэрээр энэ охиноос гарч явахыг чамд тушааж  
байна."

Муу ёрын сүнс тэр дороо охиныг орхиж одоход охин тэр  
дороо чимээгүй болжээ.



## Цээжлэх Ишлэл:

"Зөв зүйл хий"

2 КОРИНТ 8:21.

## Тол Санаа:

Зөв зүйлийг хийхдээ  
бид Есүсийг  
гэрчилдэг.

Харин охины эзэд маш их уурлав. Тэд Паул, Силас хоёрыг барьж аваад захирагчид хүргүүлсэн байна. "Энэ хүмүүс бол еврейчүүд. Тэд бидэнд олон зовлон тарьж байна" гэж тэд хашгирав. "Тэд бидний хувьд хууль ёсгүй зүйлийг хүмүүст зааж сургадаг." Тэр дороо олон хүн цугларч тэр хоёр луу уурлан давшиллаа.

Тэгээд тэд Паул, Силас хоёрыг саваа модоор цохижээ. Захирагч ч тэднийг шоронд хорив. Тэд зовлонд унасан ч гэсэн шөнө дунд Паул Силас хоёр Бурхантай ярьж, Түүнийг магтан дуулсан юм. Шоронгийн харуул болон бусад хоригдлууд сонсож байгаа зүйдээ ч итгэсэнгүй. Шөнө дундын үед гэнэт шоронгийн бүх хаалганууд хүчтэй сэгсрэгдэж унажээ. Хоригдлуудын гинж ч мултран унав. Хоригдлууд аль хэдийн зугтааж алга болсондоо гэж бодсон харуул маш их айж сандарчээ. Нэгэнт хоригдлууд нь оргочихсон болохоор заавал шийтгүүлнэ гэдгээ тэр сайн ойлгож байсан юм.

Яг тэр үед Паул "Бид бүгдээрээ эндээ сууж л байна шүү дээ" хэмээн хашгирлаа.

"Алив надад гэрэл аваад ир" гэж харуул туслахдаа тушаав. Тэр өөрийн биеэр шалгаж үзэхийг хүсжээ. Үнэхээр нэг ч хоригдол оргоогүй байсан юм.

Шоронгийн харуул Паул, Силас хоёрыг гэртээ авчирч хоол өглөө. Тэд ч харуулын гэр бүлийнхэнд Есүсийн тухай ярьж өгсөн байна. "Хүмүүс ээ, би аврагдахын тулд юу хийх ёстой вэ?" гэж харуул тэднээс асуужээ.

Паул, Силас хоёр инээмсэглээд, "Зүгээр л итгэ" гэв. "Их Эзэн Есүст итгэвэл аврагдах болно."

"Би итгэж байна" гэж тэрээр хэлээд Паул, Силас хоёрын шархыг болгоомжтой угааж ариутгаж өгсөн байна.

Үүр цайхаас өмнө Паул, Силас хоёр харуул болон түүний гэрийнхэнд усан баталгаа хүртээжээ.

Паул, Силас хоёр зөв зүйл хийсэн. Муу зүйл болж байсан ч гэсэн тэр хоёр Бурханыг магтан дуулж байсан юм. Тэд шоронгийн харуулд Есүсийн хайрыг үзүүлж чадсан. Та нар ч бас зөв зүйл хийж Есүсийн хайрыг бусдад харуулж чадна.



# Дасгал Ажил

## ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл үзсэн түүхийг хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ давтахдаа дараах хөдөлгөөнийг хийгээрэй.

**Зөв зүйлийг** .....Баруун гараа өргөх.

**хий.** .....Хоёр алгаа доош харуулж байгаад дээш нь харуул.

**2 Коринт 8:21** .....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн цээжлэх ишлэлийн гинжээ хэн нэгтэй хуваалцан мөн Паул, Силас хоёр шоронд байхдаа ямар байсан тухай түүнд ярихад нь урамшуулаарай. Эсвэл цээжлэх ишлэлийг жижиг нарийн цааснууд дээр тасалж бичээд үзүүрүүдийг нааж гинж хийгээрэй.

## ДАВАА

Хамтдаа Үйлс 16:16-34-г хамтдаа уншаарай. Асуух: Шоронгийн харуул Паул, Силас хоёрт юу хийж өгсөн бэ? Тэд хариуд нь түүнд юу хийж өгсөн бэ?

Та хэрхэн усан баталгаа хийлгэж байсан тухайгаа хүүхдэдээ ярьж өгөөрэй. Энэ таны хувьд ямар утга учиртай зүйл байсан бэ? Дараа нь хүүхдээрээ хүүхэлдэй эсвэл тоглоомон шувуунд усан баталгаа хүртээлгэж үзүүлээрэй. Толгойг нь усан дор ортол булхах ёстой.

## МЯТГАР

Та хүүхдээ шалан дээр суулгаад, хөлийг нь нугалуулаарай. Тэгээд хөлийг нь нийлүүлж уяарай. Асуух: Чи босож зогсож чадах уу? Паул, Силас хоёрт яаж хандсан бэ? Залбирахаасаа өмнө магтаалын дуу дуулаарай. Гэр бүлийг тань эсэн

мэнд байлгадагт нь Есүст талархаарай.

## ЛХАГВА

Хоосон хайрцгаар хүүхдээрээ нэгэн цамхаг бариулаарай. Дараа нь газар хөдөлж байгаа мэт болж хайрцагнуудыг сэгсрэн унагаагаарай. Асуух: Газар хөдөлж байх үед Паул, Силас хоёрт ямар санагдаж байсан бол? Хэн тэднийг хамгаалж байсан бэ? Тэд яагаад зугтаагаагүй вэ? Хүүхдийг нь хайрлаж

хамгаалж байдагт нь Есүст талархаарай. Шаббат хичээл дээр хэрэгтэй нийтийн тустай үйлчлэлд зориулах зүйл цуглуулаарай.



## ПҮРЭВ

Хамтдаа эмийнхээ сангаа үзээрэй. Шарх хаванд юу сайн болохыг ярилцаарай. Хүүхдээрээ биен дээрээ шархны лент наалгана уу. Биднийг эдгээдэг Есүст талархаарай.

## БААСАН

Оройн магтаалын цагаар хүүхдээрээ Библийн түүхийг жүжиглүүлнэ үү. Угаах хувцас хийдэг сагсанд хүүхдээ хийж, шорон болгож тоглоорой. Газар хөдөлж байгаа юм шиг сагсыг сэгсэрч хөдөлгөнө үү. Паул, Силас хоёр шиг дуулж дараа нь залбираарай.

